



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4. дэх хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 11.7, 11.8, 11.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Үйлдвэрчний эвлэлийн хороодуудаас санал авсны дараа Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын зөвлөлд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Шаардлагатай тохиолдолд ажлын хэсгийн гишүүдийн ажил үүрэгт зохицуулалт хийж, ажиллах нөхцөл бололцоогоор хангаж ажиллахыг газар, нэгжийн дарга нарт даалгасугай.

3. Хөдөлмөрийн дотоод журмын төслийг Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шинэчлэн боловсруулж, 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэг (Б.Хүсэлт)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн
А/Б/1 дугаар тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
ахлагч:

Б.Хүсэлт

(Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын
даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ахлах
мэргэжилтэн)

Гишүүд:

О.Ган-Эрдэнэ

(Захиргаа, удирдлагын газрын менежер)

Б.Ганхуяг

(Агаарын навигаци, нисэх буудлын бодлого,
зохицуулалтын газрын менежер)

Ө.Мөнгөнжигүүр

(Дотоод аудитын албаны менежер)

Б.Хоролбат

(Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Менежер)

Д.Одгэрэл

(Агаарын навигаци, нисэх буудлын бодлого,
зохицуулалтын газрын Төсөл, хөтөлбөрийн
хэлтсийн дарга)

Э.Мишээл

(Захиргаа, удирдлагын газрын ахлах мэргэжилтэн)

П.Батбаяр

(Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын
хуулийн мэргэжилтэн)

Э.Золзаяа

(Захиргаа, удирдлагын газрын хүний нөөцийн
мэргэжилтэн)

З.Туяа

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа,
хүний нөөцийн газрын менежер)

М.Тамир

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Нислэгийн
хөдөлгөөний үйлчилгээний албаны Захиргаа,
хүний нөөц, сургалтын хэсгийн захиргааны ахлах
мэргэжилтэн)

Нарийн бичгийн
дарга:

Б.Цолмонгэрэл
(Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын
дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)

---oOo---